

**ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

2022.12.02

Дархан

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт
Нэг. Төрийн захиргааны албан хаагчийн баримтлах ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргийн хүрээнд:		
1.1	Төрийн албан хаагчийн ёс зүйн талаарх мэдлэгийн түвшинг тандах, санал асуулгыг байгууллагын албан хаагчдаас авах ажлыг зохион байгуулах	2022 оны 2 сарын 22-нд байгууллагын нийт албан хаагчдын дунд ёс зүйн дүрмийн талаар мэдлэг шалгах тест шалгалт авсан. Шалгалтаар 95% дүгнэгдсэн. Цаашид энэ шалгалтыг жил 1 удаа зохион байгуулж байх, шинэ мэдээ мэдээллээр хангаж зохион байгуулна.
1.2	Байгууллагын албан хаагчдад ёс зүйн талаар мэдээлэл хийх, холбогдох байгууллагаар мэдээлэл хийлгэх	Иргэн Ц.Энхбаяр нь ГХБХБГ-ын мэргэжилтэн С.Ундрахад холбогдуулсан гомдол гаргасны дагуу байгууллагын Ёс зүйн зөвлөл 2022/04/11-ны өдөр бүрэлдэхүүнээр хуралдаж, ёс зүйн зөрчил гаргаагүй гэж дүгнэсэн. Гомдлын талаар шийдвэрлэсэн тухай мэдэгдэл дүгнэлтийг иргэн Ц.Энхбаяр болон аймгийн ЗДТГ-ын Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. Ёс зүйн зөвлөлийн шийдвэртэй холбогдуулж гомдол ирээгүй болно.
1.3	Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, байгууллагын ёс зүйн зөвлөлийн дүрмийг судлах 1 сарын аяны ажлыг зохион байгуулах	Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийг судлах сарын аяны хүрээнд ажилтан албан хаагч бүрт ЁС ЗҮЙТЭЙ ХҮНД СУРТАЛГҮЙ ТӨРИЙН АЛБА ковертай нүүр хуудастай байршуулж сурталчилан ажилласан.
1.4	Ажил хэрэгч хувцаслалт, харилцааны соёлын талаар сургалт хийх	Ажлын байран дээр зохистой зөв хувцаслах талаар 44 хуудас бүхий танилцуулга сургалт хийсэн. Сургалтаар эрэгтэй, эмэгтэй хувцаслалт, өнгө хоорондын зохицол, хэм хэмжээ, иргэдтэй хэрхэн харилцах, харилцаа хандлагыг зөв зохистой илэрхийлэх тухай сургалт хийсэн.
1.5	Ажилд шинээр орж байгаа ажилтнуудад ёс зүйн хэм хэмжээг танилцуулах ажлыг зохион байгуулах	2022 онд Шинээр орсон 2 ажилтан албан хаагчдад ёс зүйн хэм хэмжээг танилцуулж мөрдөж ажиллах тухай мэдээлэл өгсөн.
1.6	Байгууллагын ёс зүйн дүрэм, төрийн албан хаагчийн андгай, төрийн албан хаагчийн эрхэмлэх 9 зүйлийг сурталчлан таниулах, дагаж мөрдүүлэх, хэрэгжүүлэх зохион байгуулах төрийн албан хаагчдаар баталгаажуулж авах	Ёс зүйн дүрмийн мөрдөж ажиллах, эрхэмлэх 9 зүйлийг ажилтан албан хаагч бүрийн ажлын ширээний компьютерийн дэлгэцэнд /desktop/ байрлуулж өглөө бүр ажил эхлэхдээ сэргээж уншиж байхыг мэдээлсэн. Мөн тойрох хуудасаар тус бүрт нь танилцуулсан.
Хоёр. Гомдол, мэдээллийн нууцлалыг чиг үүргийн хүрээнд:		
	Ёс зүйн зөрчлийн талаарх мэдээлэл,	Мэрэгжилтэн С.Ундрахтай холбоотой

2.1	гомдол, хүсэлтийг цаасан болон цахим хэлбэрээр хүлээн авч бүртгэх,	гомдлыг цаасан хэлбэрээр бүртгэж ЁЗЗ хуралдаж тэмдэглэл үйлдсэн. Цаасаар баримтжуулсан.
2.2	Ёс зүйн зөрчлийн талаарх мэдээлэл, гомдол, хүсэлтийг судалсан тайлан, дүгнэлт, зөвлөлийн хурлын тэмдэглэлийн иж бүрдлийг хангаж, архивын нэгж үүсгэх	Ёс зүйн зөрчлийн талаарх мэдээлэл, гомдол, хүсэлтийг судалсан тайлан, дүгнэлт, зөвлөлийн хурлын тэмдэглэлийн иж бүрдлийг хавтасанд байршуулж хадаглаж байна.
2.3	Ёс зүйн зөрчлийн талаарх хагас болон бүтэн жилийн тайланг гаргаж, холбогдох газарт хүргүүлэх	2022 оны хагас жилийн тайланг төрийн албаны салбар зөвлөл болон холдогдох төрийн байгууллагад хугацаанд нь хүргүүлсэн.
2.4	Ёс зүйн зөвлөлийн хийсэн алжын тайлан, шаардлагатай бусад мэдээллийг байгууллагын www.darkhan.gazar.gov.mn цахим хуудсанд тогтмол байршуулж, нийтэд мэдээлж ёс зүйн буланг ажлуулах	Ёс зүйн зөвлөлийн хийх ажлын төлөвлөгөөг www.darkhan.gazar.gov.mn цахим хуудсанд 2022 оны 02 дугаар сарын 07 өдөр ГХБХБГ-ын даргаар батлуулан байршуулсан.
Гурав. Гомдол, мэдээллээс гадна хэвлэл, мэдээллийн хэрэгслийн мэдээллийн мөрөөр, түүнчлэн өөрийн санаачлагаар болон байгууллагын удирдлагын шийдвэрээр ёс зүйн зөрчлийг тогтоож, дүгнэлт гаргах чиг үүргийн хүрээнд:		
3.1	Байгууллагын нэрээр аймгийн болон сумын ЗДТГ-т ирүүлсэн албан хаагчдын ёс зүйн зөрчлийн талаарх мэдээлэл, шүүж, бүртгэж хүлээн авах	Иргэний гомдол мэдээллийн 1111-д 2 албан хаагчийн байгууллагын нэр дээр аймгийн ЗДТГ-т 2, нийт 4 гомдол мэдээлэл ирүүлсэн бүртгэж хариуг хугацаанд нь хүргүүлсэн.
3.2	Байгууллагын цахим хуудсанд байршуулсан цэсээр дамжуулан мэдээллийг шүүж, бүртгэх	Байгууллагын цахим хуудсанд өнөөдрийн байдлаар мэдээлэл ирээгүй байна.
3.3	Бүртгэсэн гомдол, санал, мэдээллийн дагуу Төрийн албаны хууль журмын хүрээнд ёс зүйн зөрчлийг шалган тогтоож, дүгнэлт гаргах	Бүртгэсэн гомдол, санал, мэдээллийн дагуу Төрийн албаны хууль журмын хүрээнд 4-н ёс зүйн зөрчлийг шалган, дүгнэлт гаргаж хугацаанд нь хүргүүлсэн.
3.4	Гарсан дүгнэлтийг байгууллагын даргад танилцуулж шийдвэр гаргуулах, гарсан шийдвэрийг дүгнэлтийн хамт Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлэх	2022.04.11 өдөр ирсэн иргэн Ц.Энхбаярын гомдлыг судлаж ёс зүйн зөвлөлийн хуралдаанаар шийдвэрлэж 2022.05.03 №260 тоот албан бичгээр хариуг хүргүүлсэн.

Тайлан гаргасан:

Ёс зүйн зөвлөлийн гишүүн:

Б.Мөнгөнтөгос

Тайланг хянасан:

Ёс зүйн зөвлөлийн дарга:

Б.Төмөр

